



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Б.Нямбуу Утас: 70453317, Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ЭРДЭНЭДЭЛГЭР ТАНАА

2026. 02.10 № УБД-2026/15/НД-СГД-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>250,905,941.06</u>	<u>239,810,603.62</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	250,905,941.06	239,810,603.62
351	Түүхий эд материал	213,889,471.54	208,415,567.64
35130	Эм боох материал	213,889,471.54	208,415,567.64
354	Хангамжийн материал	37,016,469.52	31,395,035.98
35410	Бичиг хэргийн материал	1,690,000.00	1,375,900.00
35420	Аж ахуйн материал	10,686,800.00	11,276,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	150,000.00	760,000.00
35470	Бусад хангамжийн материал	24,489,669.52	17,983,135.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>619,974,584.50</u>	<u>543,480,372.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	619,974,584.50	543,480,372.93
392	Биет хөрөнгө	552,622,584.50	476,060,372.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	117,594,055.00	125,252,955.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,707,100.76	-43,194,954.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,610,000.00	-66,860,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	599,689,443.85	600,456,351.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,777,199.15	-215,781,684.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,823,509.34	9,441,858.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,507,446.86	-7,507,118.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,458,248.03	12,458,248.03
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,268,924.95	-7,141,568.31
39301	Програм хангамж	250,000.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	00.00
393	Биет бус хөрөнгө	67,420,000.00	67,420,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	67,420,000.00	67,420,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>870,880,525.56</u>	<u>781,214,691.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>2,704,841.87</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,704,841.87
413	Өглөг	00.00	2,704,841.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,704,841.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>870,880,525.56</u>	<u>774,509,849.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	870,880,525.56	778,509,849.33
	Засгийн газрын оруулсан капитал	175,217,827.00	175,217,827.00
51101	Өмч-Төрийн өмч	175,217,827.00	175,217,827.00
512	Хуримтлагдсан үр дүн	681,009,343.89	589,975,710.02
51210	Өмнөх үеийн үр дүн	681,009,343.89	682,414,386.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-92,438,676.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,653,354.67	13,316,312.31

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	870,880,525.56	781,214,691.20
---	--	-----------------------	-----------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,369,099,662.96	997,345,444.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,534,939.96	31,583,394.57
120	Нийтлэг татварын бус орлого	460,534,939.96	31,583,394.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	354,280,203.68	15,519,149.27
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Үндсэн хөрөнгө/	354,280,203.68	15,519,149.27
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/бараа материал/	106,254,736.28	16,064,245.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,564,723.00	965,762,050.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	878,312,200.00	946,363,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	878,312,200.00	946,363,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,252,523.00	19,398,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,860,523.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,392,000.00	14,398,750.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	964,433,009.87	1,089,784,120.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	936,865,280.03	1,069,368,611.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	936,865,280.03	1,069,368,611.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703,600,344.39	751,123,562.74
210101	Үндсэн цалин	399,617,931.39	397,134,890.18
210102	Нэмэгдэл	209,391,711.00	242,512,322.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,641,000.00	48,678,000.00
210104	Урамшуулал	59,949,702.00	62,798,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,984,993.06	99,737,489.97
210201	Тэтгэврийн даатгал	61,107,340.06	64,147,160.30
210202	Тэтгэмжийн даатгал	7,189,098.70	7,538,955.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,621,790.53	10,040,488.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,136,591.83	3,602,177.01
210205	Эрүүл мэндийн даатгал	12,930,171.94	14,408,708.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,844,597.29	13,126,639.03
210301	Гэрэл, цахилгаан	2,345,108.29	2,326,931.03
210302	Түлш, халаалт	10,499,489.00	10,799,708.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,056,553.65	28,084,324.00
210401	Бичиг хэрэг	1,246,650.00	1,476,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,908,284.00	14,167,033.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,160,646.65	1,843,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	808,000.00	725,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,267,473.00	2,243,350.00
210408	Бараа материал акталсны зардал	1,665,500.00	7,628,991.00
2105	Нормативт зардал	25,913,263.60	56,880,327.84
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,913,263.60	56,880,327.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,008,300.00	3,023,500.00
210604	Урсгал засвар	4,008,300.00	3,023,500.00
2107	Томилолт, зочны зардал	8,416,000.00	11,460,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилолт	8,416,000.00	10,260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,252,022.00	3,775,122.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,000.00	2,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,200.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,622.00	147,922.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	83,000.00
210807	Газрын төлбөр	674,200.00	674,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,789,206.04	102,157,646.19
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,789,206.04	102,157,646.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,567,729.84	20,415,509.03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,567,729.84	20,415,509.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,567,729.84	20,415,509.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	404,666,653.09	-92,438,676.23
	Нийт үр дүн(7=3+6)	404,666,653.09	-92,438,676.23

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	908,564,723.00	965,762,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,564,723.00	965,762,050.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	878,312,200.00	946,363,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	878,312,200.00	946,363,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,252,523.00	19,398,750.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,860,523.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,392,000.00	14,398,750.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	891,694,723.00	957,762,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,694,723.00	957,762,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	864,126,993.16	937,346,540.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	702,859,429.16	748,484,758.35
210101	Үндсэн цалин	398,877,016.16	397,200,927.66
210102	Нэмэгдэл	209,391,711.00	239,877,077.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,641,000.00	48,678,000.00
210104	Урамшуулал	59,949,702.00	62,728,752.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,984,993.06	99,671,452.49
210201	Тэтгэврийн даатгал	61,107,340.06	64,081,122.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,189,098.70	7,538,955.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,621,790.53	10,040,488.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,136,591.83	3,602,177.01
210205	Эрүүл мэндийн даатгал	12,930,171.94	14,408,708.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,844,597.29	13,126,639.03
210301	Гэрэл, цахилгаан	2,345,108.29	2,326,931.03
210302	Түлш, халаалт	10,499,489.00	10,799,708.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,268,353.65	21,037,633.00
210401	Бичиг хэрэг	1,504,850.00	1,197,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,908,284.00	14,167,033.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,160,646.65	1,843,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	808,000.00	1,005,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,886,573.00	2,824,650.00
2105	Нормативт зардал	21,917,298.00	34,415,936.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,557,298.00	34,415,936.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,360,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,584,300.00	5,375,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	925,000.00
210604	Урсгал засвар	4,584,300.00	4,450,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,416,000.00	11,460,000.00
210702	Дотоод албан томилолт	8,416,000.00	11,460,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,252,022.00	3,775,122.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,000.00	2,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,200.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,622.00	147,922.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	83,000.00
210807	Газрын төлбөр	674,200.00	674,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,567,729.84	20,415,509.03

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,567,729.84	20,415,509.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,567,729.84	20,415,509.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,870,000.00	8,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,870,000.00	8,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,870,000.00	8,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,870,000.00	8,000,000.00
220001	Барилга байгууламж	15,000,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	00.00	8,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,870,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-16,870,000.00	-8,000,000.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,667,074.67	276,328,970.80	00.00	466,213,872.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	13,720.00	00.00	13,720.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,217,827.00	14,667,074.67	276,342,690.80	00.00	466,227,592.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	404,666,653.09	00.00	404,666,653.09
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,653,354.67	681,009,343.89	00.00	870,880,525.56

D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,653,354.67	681,009,343.89	00.00	870,880,525.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,405,042.36	00.00	1,405,042.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,217,827.00	14,653,354.67	682,414,386.25	00.00	872,285,567.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,337,042.36	00.00	00.00	-1,337,042.36
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-92,438,676.23	00.00	-92,438,676.23
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	13,316,312.31	589,975,710.02	00.00	778,509,849.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.03	97.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.03	97.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.03	97.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,553,800.00	748,484,758.35	7,069,041.65	99.1%
210101	Үндсэн цалин	396,879,400.00	397,200,927.66	-321,527.66	100.1%
210102	Нэмэгдэл	275,825,000.00	239,877,077.99	35,947,922.01	87.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,467,400.00	48,678,000.00	-14,210,600.00	141.2%
210104	Урамшуулал	48,382,000.00	62,728,752.70	-14,346,752.70	129.7%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,684,900.00	99,671,452.49	5,013,447.51	95.2%
210201	Тэтгэврийн даатгал	68,507,200.00	64,081,122.82	4,426,077.18	92.5%
210202	Тэтгэмжийн даатгал	7,141,600.00	7,538,955.65	-397,355.65	105.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,210,600.00	10,040,488.96	1,170,111.04	89.6%

210204	Ажилгүйдлийн даатгал	3,565,100.00	3,602,177.01	-37,077.01	101.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,260,400.00	14,408,708.05	-148,308.05	101.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,765,700.00	13,126,639.03	639,060.97	95.4%
210301	Гэрэл, цахилгаан	2,937,900.00	2,326,931.03	610,968.97	79.2%
210302	Түлш, халаалт	10,827,800.00	10,799,708.00	28,092.00	99.7%
2104	Хангамж, бараа материалын зардал	19,836,500.00	19,452,233.00	384,267.00	98.1%
210401	Бичиг хэрэг	1,381,500.00	1,197,900.00	183,600.00	86.7%
210402	Тээвэр, шатахуун	14,562,100.00	14,167,033.00	395,067.00	97.3%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	1,401,400.00	1,040,600.00	57.4%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	618,100.00	1,005,000.00	-386,900.00	162.6%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	832,800.00	1,680,900.00	-848,100.00	201.8%
2105	Нормативт зардал	37,314,700.00	34,415,936.10	2,898,763.90	92.2%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,087,200.00	34,415,936.10	1,671,263.90	95.4%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,227,500.00	00.00	1,227,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,554,400.00	1,000,000.00	3,554,400.00	22.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,479,400.00	925,000.00	3,554,400.00	20.7%
210604	Урсгал засвар	75,000.00	75,000.00	0.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	8,500,000.00	8,460,000.00	40,000.00	99.5%
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	8,460,000.00	40,000.00	99.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,153,300.00	1,706,722.00	446,578.00	79.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	480,000.00	0.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	324,000.00	324,000.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	106,800.00	00.00	106,800.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,900.00	147,922.00	2,978.00	98.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,100.00	66,000.00	13,100.00	83.4%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	406,700.00	83,000.00	323,700.00	20.4%
210807	Газрын төлбөр	605,800.00	605,800.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.03	97.9%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.03	97.9%

131001	Улсын төсвөөс санхүүжих	946,363,300.00	926,317,740.97	20,045,559.00	97.9%
--------	----------------------------	----------------	----------------	---------------	-------

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,028,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,028,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,028,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,585,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	441,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,143,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,375,000.00
210604	Урсгал засвар	4,375,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,068,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00
210807	Газрын төлбөр	68,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,000,000.00
223001	Бусад хөрөнгө	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19028800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,028,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,028,800.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зоонозын өвчин судлалын төв нь аймгийн хэмжээнд байгалийн голомтод, шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчнөөс хүн амыг сэргийлэх, тэмцэх, тархвал судлалын иж бүрдмэл арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн зорилго бүхий тусгай дэглэмийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Байгууллагын зорилго, зорилт

Зорилго:

Байгалийн голомтот халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, лабораторид суурилсан тандалт судалгааг эрчимжүүлэх, халдвар эсэргүүцэх оновчтой зөв бодлого, зохицуулалтаар хангах нь эрхэм зорилго юм.

Зорилтууд:

- Шинжлэх ухааны шинэ дэвшилтэт технологи, инновацыг мэргэшсэн хүний нөөцийн чадавхтай хослуулан хүн амыг Зоонозын өвчний эрсдэлээс сэргийлэх.
- Зоонозын шалтгаант халдварын эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах,
- Байгалийн голомтот Зоонозын халдварт өвчний тархвал судлал, тандалтын тогтолцоог өргөжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зоонозын өвчин судлалын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 87,589.5 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	250,905.9	239,810.6	-11,095.3
Үндсэн хөрөнгө	619,974.6	541,404.1	-78,570.5
Нийт хөрөнгө	870,880.5	781,214.7	-89,665.8
Өр төлбөр	-	2,704.8	2,704.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	870,880.5	778,509.8	-92,370.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	870,880.5	781,214.7	-89,665.8

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгө болон авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 239,810.6 мянган төгрөг болж 11,095.3 мянган төгрөгөөр буурсан нь 16,064.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм боох материал хүлээн авсан, тайлант онд 7,628.9 мянган төгрөгийн бараа материал акталж, 78,516.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 541,404.1 мянган төгрөг болж 78,570.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 8,000.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, тайлант онд 102,157.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 21,662.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,704.8 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварын өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 778,509.8 мянга төгрөг болж 92,370.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,136,162.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 164,013.6 мянган төгрөгөөр бууруулж 972,148.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 942,363.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 29,785.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 926,317.7 мянган төгрөг буюу 97,9% хувьтай байгаа нь санхүүжилт 29,785.1 мянган төгрөг дутуу ирж, үндсэн үйл ажиллагааны зардлыг 20,045.6 мянган төгрөгөөр хэмнэж, төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсөв 71601- /80101/	946,363.3	926,317.7	20,045.6	97.9%
	Нийт дүн	946,363.3	926,317.7	20,045.6	97.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,398,8 мянга, ЗГНХ Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,000.0 мянга, нийт 19,398.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнээс шуудан холбооны зардалд 441.6 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 1,143.8 мянга, урсгал зардалд 4,375.0 мянга, дотоод албан томилолтод 3,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 2,000.0 мянга, газрын төлбөрт 68.4 мянга, барилга байгууламжид 8,000.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

				/мянган төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар	
1	Унаа, хоолны зардал	48,678.0	2025 онд нэг өдрийн хоолны зардал 18,0 мянган төгрөгөөр тооцож жилийн 48,678.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.	

2	Гадаад томилолт, арга хэмжээ	1,200.0	Гадаад томилолтын зардалд 1,200.0 гарсан байна.
3	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
4	Программ хангамж	0.0	Бичиг хэргийн программ ашиглаж байгаад акталсан.
5	Сургалт, семинар	-	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	-	Увс аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2025 онд 25 орон тоо ажиллахаар батлагдсанаас тодотголоор 2 орон тоо цомхотгож 23 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	-	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зоонозын өвчин судлалын төв нь 2025 онд тендер зарлаагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 964,433.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 9,644.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 7,715.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,087,707.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,877.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,701.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зоонозын өвчин судлалын төвийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зоонозын өвчин судлалын төв нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 174, хугацаа хоцроосон 7, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд аудитаар зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 35,503.0 мянган төгрөгийн 4 зөрчилд 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 30 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,218.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд 1 залруулга хийлгэж, 1 төлбөрийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа

Гадаад томилолтын 1,200.0 мянган төгрөгийн зардлыг үр дүнгийн тайланд дотоод томилолтын зардалд тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаал “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.1 Төлбөрийн акт

Зоонозын өвчин судлалын төвийн нян судлагч эмч Д.Балжиннямд хөдөлмөрийн харилцаа дуусгавар болоход ээлжийн амралтын цалинг 3,018.6 мянган төгрөгийг тооцож олгоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6 дахь заалтад “Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх заалтад “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтад “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, 110 дугаар зүйлийн 110.3 дахь заалтад “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ноогдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно” гэж заасныг зөрчсөн нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж олгосон 3,018.6 мянган төгрөгийн ээлжийн амралт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Дээрх актын биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР


/М.БАТСУУРЫ/
/М.БАТ-АМГАЛАН/
/Б.НЯМБУУ/

2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр